Дэлүүн сумын Эрүүл мэндийн даргын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/39 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна. Уг баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 399.4 сая төгрөгөөр буюу 27 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,081.14 | 1,751.91 | 670.77 |
| Авлага | 2,753.87 | 185,926.36 | 183,172.49 |
| Бараа материал | 77,320.97 | 103,380.90 | 26,059.92 |
| Үндсэн хөрөнгө | 1,402,778.86 | 1,592,327.13 | 189,548.27 |
| **Нийт хөрөнгө** | **1,483,934.85** | **1,883,386.30** | **399,451.45** |
| Өр төлбөр | 27,366.00 | 96,889.21 | 69,523.21 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,456,568.85 | 1,786,497.09 | 329,928.24 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,483,934.85** | **1,883,386.30** | **399,451.45** |

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст 1.7 сая төгрөг болж 0.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлага дансанд оны эхэнд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн 2.5 сая төгрөгийн авлагатай байсныг барагдуулж, оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн 2.0 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн 183.9 сая төгрөгийн, нийт 185.9 сая төгрөгийн авлагатай авлагатай гарсан байна.

Бараа материалын данс оны эцэст 26.1 сая төгрөгөөр нэмэгдэж 103.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эм боох материалын үлдэгдэл 32.3 сая төгрөг, аж ахуйн материал 38.7 сая төгрөг, хүнсний материалын үлдэгдэл 1.4 сая төгрөг, бусад хангамжийн материал 31.0 сая төгрөг байна. Тайлант онд үнэ төлбөргүй 0.8 сая төгрөгийн эм боох материал, 0.1 сая төгрөгийн аж ахуйн материал, 19.1 сая төгрөгийн хангамжийн материалыг ЭМЯ-аас хүлээн авсан байна.

Төсвийн хөрөнгөөр 226.8 сая төгрөгийн материал худалдан авч, үйл ажиллагаандаа 220.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,592.3 сая төгрөг болж 189.5 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 11.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүй 295.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 329.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нь тайлант үеийн үр дүн 329.9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны батлагдсан төсөв 1,808.8 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг  Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,739.3 сая,  орон нутгийн төсвөөс  санхүүжих эх үүсвэрийг 69.5 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 1.1 сая төгрөгөөр  баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд  1,739.3 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 69.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж, 1.1 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулахаар байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,559.6 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 69.5 сая төгрөгийн санхүүжилт авч, нийтдээ 1,629.1 сая төгрөгийн зарлага, санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, 1.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,628.5 сая төгрөг буюу 90 хувьтай байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөвлөснөөс 178.6 сая төгрөгөөр бага санхүүжилт авсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | | | | |
| 1 | Ажилгүйдлийн даатгал | 1,167,335.10 | 1,167,335.10 | 0.00 | 100% |
| 2 | Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ | 571,964.90 | 391,651.67 | -180,313.23 | 68% |
| 3 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 69,518.40 | 69,504.74 | -13.66 | 100% |
| | **Дүн** | **1,808,818.40** | **1,628,491.51** | **-180,326.89** | **90%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв  2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

#### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв нь 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд 226.8 сая төгрөгийн бараа материал, 11.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын  газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,315.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 13.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 35 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг хугацаа хоцроож байршуулсан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байршуулаагүй,  аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга

хэмжээний тайланг байршуулаагүй, тайлант оны эцэст өр, авлага үүсгэсэн 60,6 сая төгрөгийн 2 шийдвэрийг байршуулаагүй мэдээлсэн байдлын хэрэгжилт 93.8 хувьтай байна.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хувийг харгалзан үзэж байршуулаагүй мэдээлээгүй нөхөж байршуулж, зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөв.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 308.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 17.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 6 албан тушаалтанд хариуцлага ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | **2** | **17,988.4** | **1** | **10,342.4** | **58%** |
| Албан шаардлага | 5 | 308,102.1 | 5 | 308102.1 | 100% |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 0 |
| **Нийт дүн** | 8 | 326,090.5 | **7** | 318,445.5 | 98% |

Тайлант онд хэрэгжилтийг давтан шалгахад сахилгын шийтгэл ногдуулах 2 албан шаардлага болон 10.3 сая төгрөгийн төлбөрийн 1 ш актын биелэлтийг хугацаандаа ирүүлсэн, бусад албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг программ хаасны дараа 12 дугаар сарын 15-аас хойш ирүүлсэн тул 2024 оны биелэлтээр тооцогдоогүй хугацаа хэтэрснээр бүртгэгдсэн байгаа.

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Энэхүү аудитаар илэрсэн зөрчилтэй асуудлуудыг дараагийн аудитаар эрсдэл тодорхойлох, горим сорил хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, төсвийн зарцуулалт, цалингийн зардал, эмийн болон шатахууны тайлан, тооцоог дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийтдээ 386.8 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс, 386.8.1 сая төгрөгийн алдааг залруулав. Үүнд: *Залруулсан алдаа*

- НДШ-ийн 2.0 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 183.9 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгасан.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан 17.8 сая төгрөгийн бараа материал, 0.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тайланд тусгаагүй орхигдуулсан.
- Тавилга, аж ахуй эд хогшлын элэгдлийг 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Бараа үйлчилгээний зардлын өглөгийг 4.0 сая төгрөгөөр илүү, байгууллагад төлөх өглөгийг 6.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 179.6 сая төгрөгөөр дутуу,

Аудитаар нийтдээ 111.0 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 11.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 38.8 сая төгрөгийн зөрчилд нэг албан тушаалтанд хариуцлага албан шаардлага, 66.4 сая төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар 11.6 сая төгрөгийн зөрчилд зөрчилд 2 төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1. Ажилчдын цалингаас нийтдээ 99,811.2 мянган төгрөгийн татварыг суутган авч, 99,649.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 161.9 мянган төгрөгийн татварыг төсөвт дутуу төвлөрүүлэн, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д "Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 “бүх өр төлбөр”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос 10 хувиар тооцож албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д “бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт дутуу төвлөрүүлсэн 0.16 сая төгрөгийг байгууллагын төсвөөс нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Тайлант оны эмийн орлого ба зарцуулалтын баримт дутуу, өмнөх онд эмийн тайлан гаргаагүйтэй холбоотой тайланд оны эмийн тайланд хийсэн тооцоогоор 11.4 сая төгрөгийн дутагдал гарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.2-д "тасралтгүй байх", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-т “анхан шатны баримт бүрдүүлэх”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эмийн тайлангаар илэрсэн 11.4 сая төгрөгийн зөрүүг эмийн санчаар төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага**

Аудитаар 38.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв.Үүнд:

Эм, шатахууны бүртгэл тооцоо, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, бүртгэл хөтлөлт, зарцуулалтад холбогдох журмын дагуу давхар хяналт хэрэгжээгүйгээс тайланд оны эмийн тайланд хийсэн тооцоогоор 11.4 сая төгрөгийн дутагдал гарсан, шатахууны зардлаас хувь хүмүүст 27.3 сая төгрөгийн шатахууны талон бичиж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “.... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.4-д “ил тод байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэсэн заалтууд,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.2-д "тасралтгүй байх", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-т “анхан шатны баримт бүрдүүлэх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах

үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын эм, шатахууны төсвийг үр ашиггүй зарцуулсан, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, албан үүргээ биелүүлээгүй Эрүүл мэндийн төвийн дарга М.Нурсаулед сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Аудитаар 60.6 сая төгрөгийн зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өгөв.Үүнд:

***1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал***

1.1 Илрүүлэлт:

Эрүүл мэндийн төв нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана." гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж*: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах.

***2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

2.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд санхүүгийн тайланг хугацаа хоцроож байршуулсан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байршуулаагүй, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй, тайлант оны эцэст өр, авлага үүсгэсэн 60,6 сая төгрөгийн 2 шийдвэрийг байршуулаагүй мэдээлсэн байдлын хэрэгжилт 93.8 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....", 6 дугаар зүйлийн 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.5-д "........., аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор, 6.4.8-т "...... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэснийг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлээгүй аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, тайлант оны эцэст өр, авлага үүсгэсэн 60,6 сая төгрөгийн шийдвэрүүдийг нөхөж байршуулж, зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөв.

*Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг* ***Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор****, зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| НДШ-ийн 2.0 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгасан | 1 | 2,045.2 | 1 | 2,045.2 | | | 1 | 2,045.2 | | | | |
| ЭМД-ын сангаас авах санхүүжилтийн авлагыг дутуу тайлагнасан. | 1 | 183,881.2 | 1 | 183,881.2 | | | 1 | 183,881.2 | | | | |
| Үнэ төлбөргүй БМ-ыг тайланд тусгалгүй орхигдуулсан | 1 | 17,859.1 | 1 | 17,859.1 | | | 1 | 17,859.1 | | | | |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан 0.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тайланд тусгалгүй орхигдуулсан. | 1 | 495.0 | 1 | 495.0 | | | 1 | 495.0 | | | | |
| Элэгдлийг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 88.0 | | | 1 | 88.0 | 1 | 88.0 | | | | |
| Өр төлбөрийг 2,8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 2,828.0 | 1 | 2,828.0 | | | 1 | 2,828.0 | | | | |
| Батлагдсан төсвийг дутуу тайлагнасан. | 1 | 179,642.5 | 1 | 179,642.5 | | | 1 | 179,642.5 | | | | |
| Дүн | **7** | **386,839.0** | **6** | **386,839.0** | **1** | **88.0** | **7** | **386,839.0** | | | | |

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингаас суутгасан 0.16 сая төгрөгийн ХХОАТ-ыг төсөвт дутуу төвлөрүүлсэн | 1 | 161.9 | 1 | 161.9 | | | | | | | | |
| Эмийн тайлангаар 11.4 сая төгрөгийн дутагдал гарсан. | 1 | 11,429.9 | 1 | 11,429.9 | | | | | | | | |
| Эмийн бүртгэл тооцоонд хяналт хэрэгжүүлээгүй, хувь хүмүүст 27.3 сая төгрөгийн шатахууны талон олгосон, албан үүргээ биелүүлээгүй. | 1 | 38,771.4 | | | | | | | **1** | **1** | | |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, тайлагнаагүй | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **4** | **50,363.2** | **2** | **11,591.8** | | | **1** | | **1** | **1** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан | 1 | 60,643.2 | | | 1 | 60,643.2 | | |
| Дүн | 1 | 60,643.2 | | | 1 | 60,643.2 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |